

Living the Lotus

7

2023

Buddhism in Everyday Life

VOL. 214




Rissho Kosei-kai of Hawaii

Living the Lotus
Vol. 214 (2023.07)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Б.Мөнхцэцэг, Т.Оюу-Эрдэнэ
Эхийг хянасан: Ш.Зоригмаа
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэг
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami
-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуульа гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



Бие сэтгэлийг тэтгэх “хоол”-ны тухай

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Бурханы сургаал дах дөрвөн шим тэжээл

Бид бүхэн “амьдрахын тулд” хоол хүнсийг хэрэглэдэг. Ингэж авсан шим тэжээлээр дамжуулж бид бие сэтгэлийн үйл ажиллагаагаа хэвийн хадгалдаг.

Нөгөөтэйгүүр хэмжээнээсээ илүүдсэн хоол хүнсэнд шунадаг хүнийг Шагжамүни бурхан “их идээд хэвтэж унтахыг илүүд үздэг, хомхой мунхаг хүн нь эзнийхээ өгсөн тэжээлийг идээд таргалах гахайтай адил” (Дармапада сургаал) гэж хатуу шүүмжилсэн байдаг. Шагжамүни бурхан “хоол хүнсийг хүртэх боловч хэтрүүлж болохгүй” гэж айлдсан байдаг бол, Бурханы сургаалд ямарч хэмжээтэй бай хоол хүнсийг хүртэхдээ талархсан сэтгэлийг мартаж болохгүй гэдгийг сургадаг. Энэ талархал нь олон учрал тохиолоор бий болсон хоол хүнсийг үр ашиггүй хэрэглэхгүй байх, мөн амь насыг хүндэтгэх сэтгэлтэй холбогддог. Улмаар бурханы шашин нь бие сэтгэлийг эрүүл байлгах “шим тэжээл”-ийг амаар ордог хоол хүнсээр хязгаарладаггүй онцлогтой.

Тэгвэл бурханы шашинд хоол хүнснээс гадна өөр юуг “шим тэжээл” гэж үздэг вэ?

Нэгдүгээрт нүд, чих, хамар, хэл, бие, сэтгэл гэх мэдрэхүйн эрхтэнээрээ дамжуулж хүлээн авах мэдээллийг шим тэжээл гэж үздэг. Энэ нь хэрхэн хүлээн авахаас шалтгаалж бидний шунал, уур бухимдлын сэтгэлийг дэврээх тохиолдол байхад амгалан тайван сэтгэлийг хөгжүүлэх үр болох тохиолдол ч байна.

Түүнчлэн “хийхийг хүссэн зүйл”, эсвэл “ийм болмоор байна” гэсэн бодол, хүслийг сэтгэлийн шим гэж бас үздэг. Өөдрөг бодлоос эрч хүчтэй үйл хөдлөл үүсдэгийн адил ямар бодол, хүслийг тээхээс хамаарч сэтгэл, үйл хөдлөл ч өөрчлөгддөг. Мөн туршлага болон зуршлаас үүсэн бий болсон ухамсар эсвэл өвөг дээдсээс уламжлагдан ирсэн мэдлэгт тулгуурлах ухамсар, аль нь ч байсан “сэтгэлийг тэтгэх шим тэжээл” гэж үздэг.

Хоол хүнсийг багтаасан эдгээр дөрвийг бурханы сургаалд “дөрвөн хоол” гэж нэрлэдэг. Хоол хүнс нь биеийг бүтээдэг бол харин төрөл бүрийн мэдээлэл болон бие сэтгэлээрээ хүлээн авах мэдрэмж нь сэтгэлийг хөгжүүлдэг бөгөөд үүний ачаар бид амьд байгаа гэсэн үг юм.

Зэн урсгалд хоол идэхийн өмнө уншдаг “таван мэдрэхүйн шүлэг”-ийн



төгсгөлд “гэгээрэлд хүрэхийн тулд одоо энэ хоолыг хүртэнэ” гэсэн мөрт байдаг.

Энд дурдах “хоол” гэдэг нь эрүүл биеийг хадгалахын төлөөх хоол болон уух зүйлсийг хэлж байгаа боловч “дөрвөн хоол” гэдэгт дүйцүүлэн тайлбарлавал үргэлж бусдыг бодож чаддаг хүн болохын тулд сэтгэлдээ сайн чанарын шим тэжээлийг авах нь чухал гэсэн үг юм.

Тэнцвэртэй хэрэглэх тухай


Биеийнхээ эрүүл мэндэд анхаарч бид биед муу нөлөөтэй зүйлсийг идэж хэрэглэдэггүй. Үүнтэй адил сэтгэлийн эрүүл мэндийнхээ төлөө юуг “идэж” эсвэл “идэхгүй” байх хэрэгтэй гэж та бүхэн бодож байна вэ? Өдөр дутамдаа юуг харж, сонсож, ярихад сэтгэл тавгүйтэж, ямар хүнээс, ямар үг болон үзэмжнээс сэтгэлийн таашаал авч байна вэ гэдгээ бодож үзэцгээе.

“Хөгжлийн гэр” шашны байгууллагын үүсгэн байгуулагч Танигүчи Масахару(1893–1985) багштан “хоол хүртэх нь өөрийн дотор орших сүнсэндээ барих хамгийн чухал зан үйл юм” гэж бичсэн байдаг бөгөөд бурханы шашны байр суурьнаас аваад үзвэл өөрийн болон бусдын бурханлаг чанарыг нээх “хоол” бол талархал болон бусдын төлөө гэсэн сэтгэл шингэсэн үг болон үйлдэл юм. Энэ нь хүний амьдралыг илүү утга учиртай болгодог “сэтгэлийн шим тэжээл” болдог гэсэн үг юм.

Гэхдээ бодит байдал дээр уур бухимдал, үзэн ядалтыг төрүүлэх үгийг сонсох эсвэл өөрөө хэлэх, мөн шуналыг дэврээх мэдээлэлд барьц алдах үе байдаг. Тиймээс хэтэрсэн шунал, би төвт аминч үзэл гэсэн хорыг аль болох бие сэтгэлдээ нэвтрүүлэхгүй байх, хүртдэг хоол ундтай ижил юуг ч “дуртай дургүй гэж ангилалгүй, хэмжээг нь тааруулж, тэнцвэртэй хэрэглэх” гэдгийг анхаарах хэрэгтэй.

“Зүгээр л амьдрах” биш “эрүүл саруул, аз жаргалтай амьдрах” нь хүн төрөлхтөнд заяагдсан нэгэн давуу эрх юм. Энэхүү мөн чанараа илүү хөгжүүлэх гэсэн утгаараа Шагжамүни бурхан “Үнэн ном (ном дармаг айлдах) нь төрөл бүрийн идээ ундаан дотроос хамгийн сайхан амт үзэмжтэй нь болой. Хурц билиг оюунаар амьдралаа жолоодож байгаа хүнийг, хамгийн дээд амьдралаар амьдарч байгаа хүн гэж нэрлэнэ” гэж айлдсан байдаг. Бурханы сургаалаас суралцаж, бусдад дамжуулж, биднийг тэтгэж байгаа олон зүйлийн ач буянд талархаж амьдрах нь эрүүл саруул, аз жаргалтай амьдрах түлхүүр билээ. Талархах сэтгэл том зүйлээс үүсэх албагүй, хоол идэхдээ “талархан хүртэе” гээд гараа хавсрах төдийд л хөгжиж байдаг.

<Косей> 2023 оны 7 сарын дугаараас



Spiritual Journey

Өвөг дээдсийн номоор дамжуулан хүртсэн буян хишиг

Гаваагийн Оюун
Улаанбаатар салбар

Энэхүү илтгэлийг 2023 оны 6 сарын 10 өдөр зохион байгуулсан УБ салбарын 19 жилийн ойн арга хэмжээн дээр тавьсан.

Гаваа овогтой Оюун би 1956 онд Улаанбаатар хотод төрсөн одоо 67 настай. 3 охин, 3 хүргэн, 6 зээтэй. Нөхөр маань өвчний улмаас 1995 онд 39 насандаа бурхан болсон. Түүнээс хойш миний бие орон гэрээ толгойлон 3 охиноо их дээд сургууль төгсгөн, айл өрх болгохын төлөө чадлаараа зүтгэсэн. Бурханы авралаар охидууд маань бүгд их сургуулиа төгсөж дээд боловсрол эзэмшихийн зэрэгцээ хүнтэй сууж, өөрсдийн гэр бүлтэй болцгоосон.

Миний бие 1979 онд МУИС-ийг барилгын материалын үйлдвэрийн технологи инженер мэргэжлээр төгсөж, түүнээс хойш өдийг болтол тасралтгүй 44 жил ажиллаж байна. Энэ хугацаанд улсын болон хувийн хэвшлийн олон байгууллагад алба хашиж байсан бөгөөд 2002 онд өөрийн барилгын салбарын зөвлөх үйлчилгээ, сургалтын компанийг үүсгэн байгуулаад 21 дэх жилдээ үйл ажиллагааг явуулж байна.

Нийгэмлэгт ороход миний номын багш мэргэжил нэгт инженер дотнын хамтран зүтгэгч Нямдаваагийн гүйцэтгэсэн үүрэг их бөгөөд түүний ачаар би амьдралд тохиолдсон зовлонгийн шалтгааныг ойлгох түүнийг даван туулах арга замыг ойлгож энэ сургаальтай учирсан.

2010 онд миний дунд охин Алтанзулын анхны төрүүлсэн охин нь 10 хан насандаа хавдраар өвдөж оношлогдоод 1 жил тасралтгүй эмчлүүлсэн боловч тус болоогүй бурхан болсон. Үүний дараа охин маань сэтгэл санааны гүн хямралд орж гэнэт унаж ухаан алдаж татдаг болж “Эплепси” гэдэг оноштойгоор 35 настайгаасаа ажил хөдөлмөр хийх чадваргүй болж группд орсон. Энэ үйл явдал миний болон охинд сэтгэлзүйн хувьд хүнд туссан.

2013 онд мэргэжил нэгт инженер, дотнын хамтран зүтгэгч Нямдаваа надад РКК байгууллагыг танилцуулсан. Дунд охиндоо санаа зовж байсан миний хувьд Нямдаваа багшийн урилгаар өргөөн дээр хааяа очиж номын уншлагад орж, хоозанд суух болов. Гэвч тэр

дороо элсэж ороогүй билээ. Учир нь өмнө нь бурханыг төдийлэн шүтэж ном судар уншдаггүй, жилдээ ганц удаа цагаан сарын эхэнд л ганданд очиж заслаа хийлгэдэг хүн байв.

Сэтгэл шаналгасан зүйл, дотоод сэтгэлээ би тэр болгон хүнд яриад байдаггүй. Удирдах албан тушаал хашиж байсан тул ажлын байрандаа ярьдаггүй. Хүүхдийнхээ санааг зовоохгүй гээд хүүхдүүддээ ярьдаггүй. Хань ижил маань бурхан болсон тул тэр болгон дотоод сэтгэлээ нээгээд ярих хань олддоггүй байсан. Харин РКК байгууллагын хооза дотор зовлон жаргал үзсэн хүмүүс нууж хаах зүйлгүй өөрийн асуудлаа ярьж, хэрхэн аврагдсан тухайгаа ярьдаг нь надад



Улаанбаатар салбарын өргөөн дээр илтгэл тавьж байгаа Оюун гишүүн

таалагдсан. Яваандаа би өөрөө ч асуудлаа ил гарган ярьж, номын андууддаа сэтгэлээ уудалдаг болсон.

Ийнхүү миний бие 2015 оны 3-р сарын 28-нд Монголын Рисшо Косей Кай нийгэмлэгт элсэн орсон.

2016-10-15-нд гэртээ зурмал бурханаа залж судараа уншиж дэг жаягийн сургалтуудад хамрагдан номын үйлээ гэртээ хийдэг болсон. Тухайн үед дунд охины гэр бүл хамт амьдардаг байсан тул аяндаа дунд охинтойгоо хамтдаа судраа уншдаг болсон. Удалгүй дунд охин маань нийгэмлэгт элсэж, ном судар уншдаг болсноор сэтгэл санаа нь өөдрөг болж уналт таталт нь ч намдаж ирсэн. Мөн дахин нэг хүү төрүүлж түүнээс хойш сэтгэл санаа нь сэргэж 2019 оноос хөнгөн ажил хийдэг болсон. Энэ үеэс би зовлонгийн шалтгааныг олж харах, сургаалыг судлах сургалтуудад хамрагдан, бурханы сургаалыг түгээх, бусдын төлөө буян үйлдэх бодьсадва болохын тулд өөрийгөө өөрчилж зүтгэх нь чухал гэж өөртөө зорилго дэвшүүлсэн.

Ингэж ном уншиж бурхантай холбогдон буян номын үйлд шамдан би бурханд өргөл өргөж эхэлсэн. Эдийн өглөг, биеийн өглөг, ном буяны өглөг. Эдгээр өглөг үйлийг хийж эхэлснээр миний дараагийн зам мөр нээгдэж 2016 оны 5-р сарын 29-нд Токио хотод очиж Ариун ордныг үзэж бурханд мөргөж үүсгэн байгуулагчийн 110 жилийн ой, олон улсын Санга нарын IV чуулганд оролцох завшаан тохиосон. Дээрх үйл ажиллагаагаар дамжуулж РКК нь хүмүүсийн сайн сайхан, дэлхийн энхтайван, улс гүрний амар тайван амьдралын төлөө нэгдмэл зорилготой олон улсын байгууллага гэдгийг ойлгож авсан.

2018 оны 10-р сарын 21-нд Ариун ордонд очиж номын багшийн цол авч, 2019 оны 5-р сарын 26-нд Ариун ордноос бурханаа залсан.

2019 оны 12-р сараас Чингэлтэй дүүргийн ахлагчийн үүрэг хүлээн авч 4 жил ажиллаж байна. Энэ хугацаанд нийгэмлэгтэй төлөвлөгөөт ажлуудыг хэрэгжүүлэхэд оролцож, шинэ хамт олныг бүрдүүлэх гишүүдийн тоог өсгөх бусдын төлөө буян үйлдэх, бурханы өргөл өргөх зэрэг ажил үүргийг гишүүдтэйгээ хамтран хийж байна. Элсэн орсон цагаасаа хойш бурханы аврал, та бүгдийн заавар зөвлөмжийн ачаар 12 хүнийг элсүүлээд байна. Энэ дотроос нэг гишүүнийхээ тухай дурдахад. Гэрт нь бурхан залж, сахилын нэрний ач холбогдолыг

тайлбарлаж, 17 ш сахилын нэрийг бүтээлгээд гэрт нь залж, өвөг дээдсийн болон сахилын нэрний номыг нь уншдаг болсон. Ингэснээр тус гишүүний эрүүл мэнд сайжирч, мөн 30 гарсан ганц бие охин нь хүнтэй сууж, хүүхэдтэй болсон сайхан үйл явдал тохиосон.

Миний сургаал түгээхэд хийж байгаа нэг гол ажил бол сахилын нэрийг захиалж бүтээлгэх, түүнийг шүншиглэх, залах, номыг нь уншихад сайн суралцах зорилго тавьж сургалтанд хамрагдан утга учир, дэг жаягийг судлан хичээж өөрийнхөө 3 үеийн сахилын нэр, ахан дүүс, хадам аав, ээж, ханьдаа, мэндэлж төрөөгүй хүүхдүүдэд 22 хүний сахилын нэр бүтээлгэж гэртээ залж номоо уншиж байна.

Мөн 2021, 2022 онд өөрийн ах, эгч, 2 хүргэнийхээ 3 үеийн сахилын нэр, мөн гишүүдийн нэрийг 44 хүнд захиалан бүтээлгэж гэрт нь залах, номоо уншиж зан үйлээ хийхэд сургаж хамтран ном уншиж буян үйлдсэнээр



Улаанбаатар салбарын өргөөнд хоозанд оролцож буй Оюун гишүүн.

дараах өөрчлөлтүүд гарлаа. Ахан дүүс гишүүдтэйгээ сард 22 өдөр сахилын нэрний ном уншиж, цахимаар хооза хийдэг боллоо.

Ийнхүү өвөг дээдсийнхээ сахилын нэрний номыг уншсанаар би эрүүл мэндтэй холбоотой 2 том давааг давсан.

Нэгдүгээрт 2020 оны 4-р сарын 7-нд мөрний үений дурангийн хагалгаанд орж баруун мөрний шөрмөс урагдсаныг оёулж эрүүл болсон.

Хоёрдугаарт өнгөрсөн оны 11 сард эрүүл мэндийн үзлэгээр тархинд 3 газар судасны цүлхэнг үүссэнийг олж илрүүлсэн. Ингээд 2023 оны 2-р сарын 3-нд дурангийн мэс засал хийлгэж, дараа нь ямар нэгэн хүндрэл үүсээгүй ба одоо эдгэрч байна. Эмчээс эрт илрүүлээгүй бол тархины цус харвалт болох магадлалтай байсан гэдгийг дуулаад цаг алдалгүй олж илрүүлсэн нь бурханы хамгаалал, ивээл байсан гэж бодогдсон. Хагалгаанд орохоор болсон тухайгаа Зоригмаа тэргүүн болон Нямдаваа багшид дуулгахад, эмчлэгч эмч нар, эмнэлгийн хамт олны сайн сайхны төлөө ном унших хэрэгтэй гэж хэлсэн тул хагалгаанд орохын өмнө номын андуудын хамтаар эмч, сувилагч нартаа зориулан ном уншсан. Тухайн үед Цагаан лянхуа гурамсан судрын уншлагыг нийгэмлэг даяараа уншиж байсан үе таарсан. Хэдийгээр би эмнэлэгт хэвтсэн байсан ч тус номын уншлагад цахимаар оролцож судраа өдөр бүр уншиж байсан. Хагалгааны төлөвлөгөөт өдөр болох 2-р сарын 3-нд Хотолд “Сайн бодьсдвагийн сүүлийн явдлыг үзэхүй хэмээх” сүүлийн бүлгийг уншиж дуусаад, ердөө 10 минутын дараа би хагалгаандаа орсон.

Хагалгааны өмнө эмч надад судасны цүлхэн тархины 3 хэсэг газарт байрлалтай байна. Нэг дор авахад хүндрэлтэй тул хагалгаа 3 удаа давтан хийлгэх шаардлагатай гэж хэлсэн байв. Гэвч тухайн өдөр дурангийн хагалгаа хийхэд саадгүй байсны ачаар нэг удаагийн хагалгаагаар 3 хэсэг цүлхэнийг нэг дор эмчилж чадсан юм. Нэг дор бүх цүлхэнг авсан тул хагалгаа багагүй сунжирч, 8 цаг үргэлжилсэн. Хүлээлгийн өрөөнд хүлээж байсан охидууд маань хагалгаа сунжирч байгаад санаа зовж, 3 уулаа жижиг судраа ээждээ зориулан эмнэлэгт уншсан гэсэн. Охидын маань залбиралын ачаар хагалгаа амжилттай дуусч, дараа нь ямар нэгэн хүндрэл үүсэлгүй сайхан эдгэж байна.

Цаашид нийгэмлэгийн үйл ажиллагааг тууштай дэмжин сургаалиа түгээх, гишүүн элсүүлэх, залгамж хойч үеэ бэлтгэж бусдын төлөө буян үйлдэхийг хичээх болно.

Эдийн өглөг

Биеийн өглөг

Ном буяны өглөг өргөсөн хүн аврагдана гэдгийг би өөрөө амьдарлаараа ойлгосон тул энэ үйлийн ач буяны тухай бусдад түгээнэ.

Мөн номын багшийн хувьд сахилын нэрийг бүтээх, шүншиглэх, бурхан болоочийн хойтын буян номын үйлийг хийж сурах, түгээн дэлгэрүүлж уян үйлдэхэд суралцаж ажиллана гэсэн зорилготой байна.

РКК байгууллагад элсэн орсноор миний ажил, амьдралд олон сайхан өөрчлөлт гарсан. Гэхдээ юу юунаас илүүтэй миний аз жаргал, эрүүл мэндийн төлөө санаа тавьж, залбирдаг, жаргал зовлонг маань хуваалцаж түшиж тулдаг номын андуудтай учирсан явдал нь хамгийн том аз завшаан гэж бодож байна.

Үүсгэн байгуулагч танд Рисшо Косей Кай нийгэмлэгийн ерөнхийлөгч болон монголын нийгэмлэгийн тэргүүн Ш.Зоригмаа, номын багш Б.Нямдаваа нарт мөн хамт олондоо намайг өдий зэрэгтэй өсгөн хөгжүүлж амар амгалан амьдрах гайхамшигт сургаальтай учруулсанд баярлалаа.



Ариун ордонд зохион байгуулагдсан «Бурхан залах ёслол»-д номын андуудын хамтаар (баруун гар талаас гурав дахь хүн)

Рисшо Косей Кай байгууллага (Зурагт ном)

Шагжамүни бурхан багшийн амьдрал ба сургаал

Хөдөлшгүй сэтгэл (Бясалгалын барамид)

Бясалгалын барамид нь зөв зорилгын төлөө сэтгэлээ тогтвортой байлгахыг хэлдэг. Бясалгал гэдэгт ордог “Зэн” хэмээх ханз нь тайван тогтвортой сэтгэл санаа гэсэн утгатай харин “Жоо” гэдэг нь сэтгэл тайван, хөдөлшгүй тогтсон байдалтай байхыг хэлдэг.

Зорилгодоо хүрэхийн төлөө чигээрээ урагшлах нь зөв бөгөөд ямар ч зүйл тохиолдсон эргэлзэж, сэтгэлээ төөрөгдүүлэхгүйгээр тайван тогтвортой байлгаж, үргэлж зүрх сэтгэлээ бурхан багшийн сургаалд чиглүүлж байх нь чухал юм.




Бяцхан мэдлэг

Самади хэмээх үг нь бас “Бясалгал” гэдэгтэй адилхан утгатай. Энэ нь оюун ухаанаа ямар нэгэн зүйлд төвлөрүүлснээр сэтгэл санаагаа тайван тогтвортой байдалд оруулахыг хэлж буй.

Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



Мөн чанарыг таних чадвар (Билиг барамид)



Өнөөг хүртэл суралцсан сэтгэлийн 5 хандлагыг амьдралдаа хэрэгжүүлэн өөрийн болгож эзэмшсэнээр “Билиг ухаан” таньд ирнэ. Энэ бол аливаа зүйлийн жинхэнэ дүр төрхийг ялгаж салгаж харах чадвар юм.

“Билиг ухаан”-ыг япон ханз үсгээр ЧИЭ гэж дуудах ба эхний “чи” гэх ханз нь юмс хоорондын ялгааг олж харах чадвар, “э” гэх ханз нь аливаа юмсын нийтлэг талыг олж таних чадварыг хэлдэг.

Жишээлбэл, та найз нөхдийнхөө онцлог шинж чанар болон өөртэйгөө адилхан зан чанарыг ойлгож нөхөрлөвөл хэрэлдэж муудалцалгүй жинхэнэ сайн найзууд болж чадна.

Мөн бие биенээ хүлээн зөвшөөрч, хүн бүрийн хувийн онцлогийг хүндэтгэж, хамтран ажиллах нь бас нэгэн чухал зүйл юм.

Бяцхан мэдлэг
Ухаанд “мэргэн ухаан” ба “билиг ухаан” гэж хоёр төрөл байдаг. Мэргэн ухаан бол өөрийн судалж суралцсан мэдлэг, туршлагаас үүсэлтэй санаа бодол юм. Харин билиг ухаан бол жинхэнэ үнэнийг ялган таньж, үнэн сургаал дээр тулгуурлан дүгнэлт гарган асуудлыг шийдвэрлэх оюун ухааны гүнзгий үйл ажиллагаа хэлнэ.





Инээмсэглэл бол тэнгэрийн цэцэг

РКК, удаах ерөнхийлөгч
Нивано Коошоо

Шуурганы дараах цэлмэг тэнгэр- Ах дүү дөрөв

“Миний ээлж болчихлоо! Алив холд”

“Жаахан байж бай л даа”, “үгүй ээ солидье”

“Жаахан л даа”, “Өө ямар сонин юм бэ! Миний ээлж болчихоод байхад”

Саяхан болтол хөгжилтэй нь аргагүй тоглож байсан хүүхдүүдийн уур амьсгал бүрхэг болоод ирлээ.

“Манайх дандаа нэг юмыг дөрвүүлээ хэрэглэх юмаа, ээлж дарааллаараа хэрэглэдэг болохоор төвөгтэй юмаа”, “манай найзынх хүүхэд бүр тусдаа тоглоомтой гэсэн”, “жаахан дүү хүний үг сонсохгүй”, “эгч болохоор хүчээр давамгайлаад л !” гээд улам бүр уур амьсгал нь ширүүссэн дөрвөн хүүхэд маань над дээр хүрч ирэв. “За яасан?” гэж асуухад, хүн бүр хэн нь хамгийн муухай зантай болох, мөн өөрөө хичнээн хэцүү байдалд байгаагаа ам уралдан ярив. Улмаар даамжирч, бусдынхаа өмнө нь гаргаж байсан муухай заны тухай хүртэл яриад амжив.

“Айлын ганц хүүхэд байсан бол сайхан байхгүй юу. Бүх юмаа ганцаараа хэрэглээд л”, “амттанаа хүртэл хуваах шаардлагагүй”, “дүү нараа харах шаардлагагүй”, “ер нь ах дүү дөрвүүлээ гэдэг хэтэрхий олондоод байна”, “нээрээ тийм шүү!”

“Санал нэгтэй байна! Ээж нь ч гэсэн тэгэж бодож байна!”

“Айн?”. Дөнгөж сая муудалцаж байснаа мартаад, санаа нэгдэж эхэлсэн манай хэд бүгдээрээ нэгэн зэрэг над руу харлаа. Эсэргүүцнэ гэж бодож байтал, харин санал нэгтэй байна гэсэнд хүүхдүүд жаахан гайхсан янзтай байв.

“Ээжид нь ч гэсэн дөрвийн дөрвөн хүүхдийн хувцсыг угаах, хатаах, эвхэж хураах үнэхээр амаргүй байна. Дуу чимээ ихтэй, ачаалалтай, гадагшаа гарахад хүртэл олуулаа болохоор бэлдэх зүйл ихтэй. Нээрээ л дөрвөн хүүхэд арай л ихдээд байна. Та нарт эгч дүү хэдүүлээ байвал дээр байна?”

Намайг ингэж асуухад хүүхдүүд “Ганцаараа байвал сайхан даа”, “Гэхдээ ганцаараа байхаар тоглох хүнгүй жаахан уйтгартай байна байхаа. Хоёр байвал яг болж байна”, “Тийм шүү! хоёр болж байна! Ээжтэй ч хамт унтаж болно” гээд баясгалантай аргагүй ярьж эхлэв.

“Ээжид нь ч гэсэн хоёр байвал аятайхан л байна” “тийм байгаа биз! Хоёр байхад яг болно” гээд бүгдийнх нь санаа нэгдлээ. Тэр үед би хүүхдүүдээсээ дахин асуулаа. “За эгч дүү хоёр байхад болох юм бол та дөрөв дотроос хэн хэн хэрэггүй гэж бодож байна?”

“За байз”, “ммм...” бүгдээрээ зэрэг бодож эхлэв. Хэсэг бодсоны дараа дөрвүүлээ бие биенийхээ царай луу харлаа. Тэгтэл том охин маань “бодоод байсан ер нь ах дүү дөрвүүлээ байх нь дээр юм байна. Хэрэггүй хүүхэд гэж угаасаа байхгүй юм байна”. “Би ч гэсэн тэгэж бодож байна!”, “би ч гэсэн!”, “ээж нь ч гэсэн тэгэж бодож байна!” бүгдийнх нь харц тулгарч, инээмсэглэв. Дургүй хүрмээр, залхмаар, уур хүрмээр үе олон байдаг боловч ах дүү дунд хэрэггүй хүн гэж байхгүй гэдгийг бүгдээрээ маш сайн



Нивано Коошоо

Рисшо Косей Кай байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн том охин бөгөөд Токио хотод мэндэлсэн.

Хуульч мэргэжлээр их сургуулиа төгссөний дараа тус байгууллагын удирдах албаны мэргэжилтэн бэлтгэх “Гакүрин” сургуулийн үндсэн ангид элсэн суралцаж төгссөн.

Өдгөө Цагаан Лянхуа Судрыг судлан суралцахын хажуугаар гишүүд болон сүсэгтэн олонд ном айлдаж, гадна дотны шашны байгууллагатай хамтрах тал дээр анхааран ажиллаж байна. Мөн тус байгууллагын удаах ерөнхийлөгчөөр сонгогдоод байгаа.

Тэрээр нөхөр Мүнэхиро болон нэг хүү, гурван охины хамт амьдардаг.

ойлгов.

“Бүгдэд нь мааш их хайртай!” гэсээр гэрэл цацруулан цэлмэсэн царайтай дөрвүүлээ нэгэн зэрэг намайг тэврэхээр ирэв. “Ээж нь ч гэсэн зөндөөө их хайртай!” гээд дөрвүүлэнг нь зэрэг тэврэв.

Бүгдээрээ надад наалдаж, тэврэлдсэн хэрнээ сайн хартал хамгийн бага дүүгээ урдаа гаргаад бүгдээрээ тэврэлдэж чадахаар мундаг гэгч нь зогссон байлаа.

<Якүшин> 2010 оны 7-р сарын дугаараас



Олон улсын хэлтсийн даргын булан



Аз жаргал, эрүүл энхийн төлөөх зам мөр

Акагава Кэйичи

Сайн байцгаана уу. Дөрвөн улирал ээлжлэн солигдож 7-р сар гарч аагим халуун зуны улирал ирлээ.

Энэ сард Нивано ерөнхийлөгчөөс “Бие сэтгэлийг тэтгэгч хоол” гэсэн сэдэвтэй айлдварыг сонслоо. Ерөнхийлөгчийн айлдварууд нь “Эрч хүчтэйгээр бурхны үйлд шамдах”-д шаардлагатай билиг оюуны тухай сар бүр өөр өөр өнцгөөс бидэнд сургаж байна. Тиймээс ч би сар бүр айлдварыг тэсэн ядан хүлээж, тухай бүрд шинэ мэдрэмжтэйгээр уншдагтаа маш их талархдаг юм.

Энэ сарын айлдвараар ерөнхийлөгч бидний бие ба оюун ухаан буддын шашны 4 хүнсэнд суурилдаг буюу өөрөөр хэлбэл 1. “Идэж уух хүнс” 2. “Зургаан мэдрэхүйгээрээ хүлээн авах мэдээлэл” 3. “Бодол болон хүсэл тэмүүлэл” 4. “Туршлага, зуршлаас үүдэх ухамсар, өвөг дээдсээс уламжлан авсан мэдлэгт үндэслэсэн ухамсар”-аар тэжээгдэн амьдарч байгаа тухай хөндөөд, “эрүүл саруул, аз жаргалтай амьдрах” явдал нь хүн төрөлхтөнд заяагдсан давуу эрх хэмээн дурджээ. Манай байгууллага шинэ коронавирус дэлгэрсэнээс хойш энэхүү “Эрүүл энх, аз жаргалтайгаар амьдрах” гэсэн үндсэн чиглэлийг бидэнд өгч байгаа билээ.

Дармапада сударт “Би өөрийнхөө хамгийн найдвартай түшиг тулгуур “ (160) гэж өгүүлсэнчлэн хэрхвэл дотоод бясалгалаар дамжуулж бүх зүйлийн нөхцөл нь би өөрөө болдог шүтэн барилдлагын ертөнцийг “эрүүл”, “аз жаргал”-аар дүүргэх вэ? Айлдваруудыг уншиж энэ сэдвийг дахин тунгаан ухамсарлаж, шинэ эрч хүчтэйгээр өөрийгөө бурхны үйлд зориулья гэж бодож байна.




Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter



🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about local Dharma centers



facebook



twitter



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp